



ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Залуучуудын хөгжлийн төвийн дүрэм,  
ажилтнуудын ажлын байрны үлгэрчилсэн  
тодорхойлолт батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны дүрмийг нэгдүгээр, тус төвийн ажилтан бөгөөд залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн Ажлын албаны нарийн бичгийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг хоёрдугаар, Сургалт хариуцсан ажилтны ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг гуравдугаар, Оролцоо, хамтын ажиллагаа хариуцсан ажилтны ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Төвийн дүрэм, ажлын байрны тодорхойлолтыг мөрдөн ажиллахыг аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн дарга, төвийн ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Залуучуудын хөгжлийн төвд ажиллах ажилтнуудын цалин хөлс болон бусад шаардлагатай зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган ажиллахыг Захиргаа, санхүү удирдлагын газар /Ш.Чинбат/, Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

4. Төвийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Залуучуудын хөгжлийн газар /Г.Батдорж/-д даалгасугай.

ДАРГА



О.АЛТАНСҮХ



## **ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Залуучуудын хөгжлийн төв (цаашид төв гэх) нь орон нутагт залуучуудад зориулсан нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төрийн үйлчилгээний нэгж мөн.
- 1.2. Энэхүү дүрэм нь төвийн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, зорилго, удирдлага, зохион байгуулалт, хариуцлага, бусад харилцааг зохицуулна.
- 1.3. Төв нь тухайн аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн дэргэд харьяалагдана. Сум, хороонд төвийг байгуулж болно.

### **Хоёр. Үйл ажиллагааны зарчим**

- 1.1. Төв нь залуучуудын хөгжлийг дэмжих төрийн болон орон нутгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулахдаа хүний эрхэд суурилсан, мэргэжлийн ёс зүйтэй байх, хууль дээдлэх, оролцоонд тулгуурласан, шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан ажиллана.

### **Гурав. Эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл**

- 3.1. Төвийн эрхэм зорилго нь залуучуудын өрсөлдөх чадвар, амьдралын чанарыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулан, тэдний оролцоонд тулгуурлан хөгжих, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэнэ.
- 3.2. Залуучуудын хөгжлийн төв нь залуучуудын салбар зөвлөлийн Ажлын алба байна.
- 3.3. Төв нь дор дурдсан үйл ажиллагааны чиглэлтэй байна. Үүнд:
  - 3.3.1. залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, залуучуудын хөгжлийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг тухайн орон нутагт зохион байгуулах, тайлагнах;
  - 3.3.2. залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах;
  - 3.3.3. залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож, тэдний саналыг хүргэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, шаардлагатай мэдээллээр хангах;
  - 3.3.4. залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт хэрэгцээнд тулгуурласан, зэрэг хандлага, зан үйлд уриалсан үйл ажиллагаа явуулах, оролцооны байгууллагуудын болон сайн дурын, хүмүүнлэгийн ажлыг дэмжих;
  - 3.3.5. хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээнд залуучуудыг холбон зуучлах;
  - 3.3.6. залуучуудад эрүүл зан үйлийн талаар зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах;
  - 3.3.7. залуучуудад гэр бүлийн боловсрол олгох сургалт явуулах;

- 3.3.8. залуу гэр бүлд тулгамдсан асуудал, бэрхшээлээ хамтран даван туулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд холбон зуучлах, дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, ярилцлага зохион байгуулах;
- 3.3.9. зорилтот бүлгийн залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, ажлын байрны мэдээллээр хангах, цагийн болон байнгын ажилд холбон зуучлах;
- 3.3.10. залуучуудад гарааны бизнес эрхлэх талаар мэдээллээр хангах, тэдний үйл ажиллагааг дэмжин ажиллах;
- 3.3.11. номын сангийн үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, цахимжуулах;
- 3.3.12. ахлах ангийн сурагчдад мэргэжил сонголтын талаар мэдээлэл зөвлөгөө өгөх;
- 3.3.13. холбогдох хууль, дүрэм, эрх зүйн бусад акт, дээд газраас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах;
- 3.4. Төв нь үйл ажиллагаандаа холбогдох хууль, тогтоомж болон төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартыг чанд мөрдөн ажиллана.
- 3.5. Төвийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах дүрэм, журмыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (цаашид агентлаг гэх)-ын даргын тушаалаар баталж, өөрчлөлт оруулна.
- 3.6. Холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг мөрдөн ажиллана.

#### **Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт**

- 4.1. Төв нь залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн Ажлын албаны нарийн бичиг, Сургалт хариуцсан ажилтан, Оролцоо, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан гэсэн орон тоотой байна.
- 4.2. Төвийн ажилтнуудыг тухайн орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/ хэлтэс (цаашид байгууллага гэх)-ийн дарга агентлагийн даргатай зөвшилцөж томилно.
- 4.3. Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг байгууллагын дарга удирдаж, үйл ажиллагааны үндсэн зохион байгуулалтыг ажилтнууд хариуцан байгууллагын даргын өмнө хариуцлага хүлээнэ.
- 4.4. Төвийн үйл ажиллагааны сар, улирал, жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг байгууллагын дарга баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 4.5. Төвийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар агентлагийн Залуучуудын асуудал хариуцсан нэгж ханган ажиллана.
- 4.6. Төв нь үйл ажиллагааны тайлан, биелэлтийг зохих журмын дагуу гарган эрх бүхий байгууллагаас тогтоосон хуваарийн дагуу хугацаанд нь агентлагт хүргүүлнэ.
- 4.7. Төвийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загвар, албан тушаалын ангилалыг агентлагийн дарга батална.
- 4.8. Төвийн ажилтнууд нь байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 4.9. Төвийн ажилтнууд нь Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллана.

### **Тав. Хориглох зүйлс**

- 5.1. Төвийн үйл ажиллагаанд дараах зүйлсийг хориглоно. Үүнд:
  - 5.1.1. төвөөр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй, хувь хүний эрхэд хүндэтгэлтэй хандах;
  - 5.1.2. үйлчлүүлэгчдийн зан үйл, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц аливаа үйл ажиллагаа, улс төрийн болон шашны номлол, эсхүл шашингүйн үзлийг сурталчлах;
  - 5.1.3. төвийн тавилга, техник хэрэгслийг үйл ажиллагааны зорилгоос бусад зориулалтаар ашиглах;
  - 5.1.4. хуульд заасан бусад;

### **Зургаа. Төвийн байр, хөрөнгө, санхүү, хариуцлага**

- 6.1. Төв нь байнгын үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий өрөө, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.
- 6.2. Төвийн үйлчилгээний жишиг зардлыг холбогдох журам, стандартын дагуу тооцож тогтооно.
- 6.3. Төвийн үйл ажиллагааны зардал нь улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хуулиар зөвшөөрсөн бусад эх үүсвэрээс бүрдэнэ.
- 6.4. Төв нь байгууллагын даргын зөвшөөрлөөр хандив, тусламж авч, данс бүртгэл хөтлөн зарцууна.
- 6.5. Төвийн ажилтнууд нь байгууллагын даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хагас, бүтэн жилээр дүгнүүлнэ.
- 6.6. Төвийн ажилтнууд үйл ажиллагаандаа төрийн албаны хэм хэмжээ, мэргэжлийн ёс зүй, зарчмыг чанд мөрдөн ажиллана.

### **Долоо. Бусад**

- 7.1. Энэхүү дүрмээр зохицуулснаас бусад харилцааг холбогдох хууль, тогтоомжоор зохицуулна.
- 7.2. Дүрэмд өөрчлөлт оруулах асуудлаар газрын залуучуудын асуудал хариуцсан нэгжийн удирдлага газрын захиргааны зөвлөлийн хуралд санал оруулан хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.
- 7.3. Энэхүү дүрэм, нэмэлт өөрчлөлт оруулсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.